



БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/382

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 2017 оны шилдэг шалгаруулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, 29.2 дахь хэсэг, Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан “Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шагналын төрөл, түүнийг олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтыг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай ажилласан 2017 оны “Хөдөлмөрийн аварга”, “Шилдэг төр захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон”, “Шилдэг сурагч”, “Шилдэг оюутан” шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга

Д.Уламбаяр
Эдийн засгийн хөгжлийн асуудал хариуцсан төслийн
удирдагч-Засаг даргын орлогч

Гишүүд:


Т.Батцогт
Дэд бүтэц, хот төлөвлөлт хариуцсан төслийн удирдагч
-Засаг даргын орлогч
Б.Амартүвшин
Засаг даргын Тамгын газрын дарга
А.Пүрэвдулам
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
Ц.Өсөхбаяр
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
С.Сувд-Эрдэнэ
Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Б.Отгонхүү
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга
С.Жавхлан
Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Нарийн бичиг

Ц.Бадам-Очир
Шагнал, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал хариуцсан
мэргэжилтэн

2. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг /Д.Уламбаяр/-т, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан ажиллахыг Хэвлэл, мэдээллийн алба /Д.Цэнгэлмаа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Т.БАЯСАХ